



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/322

Булган сум


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх үеийн аюулгүй найдвартай бэлэн байдлыг хангахад анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор ажлын байрны сургалтын удирдамжийг 1 дүгээр, хөтөлбөрийг 2 дугаар, төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардлагатай 1,280,000 (нэг сая хоёр зуун наян мянга) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ



АЖЛЫН БАЙРНЫ ДАДЛАГА СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Сургалтын зорилго:

Яаралтай цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үеийн аюулгүй найдвартай бэлэн байдлыг хангах ажлын байрны дадлага сургалтыг зохион байгуулах

Сургалтын зорилт:

1. Хувийн тохироо болон цусны бүлэг тодорхойлох шинжилгээний зорилго, эмнэл зүйн ач холбогдол, онолын үндэс, шинжилгээний бэлтгэл, баримтжуулалттай холбоотой мэдээллийг өгөх

2. Шинжилгээний сорьц цуглуулах, хувийн тохироо тодорхойлох, цусны бүлэг үзэх шинжилгээг гардан хийх, дүгнэх баримтжуулах

3. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үеийн яаралтай бэлэн байдал, гардан хийж дүгнэх баримтжуулах

4. Донор сонгох, элсүүлэх, сурталчлах арга барилд суралцах

Сургалтын хэлбэр: Онол, дадлага

Сургалт үргэлжлэх хугацаа:

2023 оны 05 дугаар сарын 02-оос Дашинчилэн суманд 2 өдөр

2023 оны 05 дугаар сарын 08-аас Хутаг-өндөр суманд 2 өдөр

Сургалт зохион байгуулах байршил: Дашинчилэн, Хутаг-өндөр сумдын Эрүүл мэндийн төв

Сургалтад хамрагдах мэргэжилтний тоо: Хойд, урд бүсийн ЭМТ-үүдийн 40 мэргэжилтэн /эмч, лаборант, сувилагч, эх баригч/

Сургалтын бэлтгэл ажил:

Танхимын дэлгэц, проектор, микрофон, дуу өсгөгч, хурлын ширээ, сандал, центрфуг, вакуумтейнер/улаан, ягаан таглаатай 100,100 ширхэг, Анти А, В, Д цоликлон 4,4 флакон, кумбсын урвалж, лисс уусмал тус бүр 4 флакон, пепитк, дусал тохируулагч, систем./ Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх стандарт номод тусгасан тэргэнцрийн бэлэн байдлаас авхуулаад бүх багцуудыг бусад сумд үлгэр жишээ болохуйц бэлтгэж ирсэн байх.

Сургалтын үр дүн:

-34 мэргэжилтэн бэлтгэгдэнэ.

-Донор элсүүлэлт сайжирна. Яаралтай цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үеийн бэлэн байдал сайжирна.

-Эмч мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирна.

Аймгийн Засаг даргын 2023 оны
 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/322 дугаар
 захирамжийн 2 дугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ДАДЛАГА СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

цаг	Сургалтын хөтөлбөр	Сургалтын хэлбэр	хугацаа	Хариуцах багш
1	2	3	4	5
Сургалтын эхний өдөр 2023.05.02				
09:00	Бүртгэл		20 мин	Дашинчилэн ЭМТ
09:05-09:35	“Донорын талаар төрөөс баримтлах бодлого”, “Донорын тухай” хуулийн хэрэгжилт	лекц	30 минут	Цусны салбар төвийн эрхлэгч их эмч Б.Шижирбаатар
09:35-10:35	Донор сонгох, донор элсүүлэхэд юуг анхаарах вэ	лекц	1цаг	ЦСТ бага эмч Г.Туяа
10:35-11:30	Цус цусан бүтээгдэхүүний захиалга, зохистой хэрэглээ	Онол-дадлага	1 цаг 05 минут	Цусны салбар төвийн их эмч Б.Шижирбаатар, бага эмч Г.Туяа
11:30-11:40	Цайны завсарлага			
11:40-13:00	Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үед хөтлөгдөх анхан шатны маягт түүнд тавих хяналт	Онол-дадлага	1 цаг 20 минут	Цусны салбар төвийн бага эмч Г.Туяа
13:00-14:00	Цайны завсарлага			
14:00-16:30	Сумын эрүүл мэндийн төвд яаралтай цус сэлбэх үед донороос цус бэлтгэх арга зам	Онол-дадлага	2 цаг	Цусны салбар төвийн бага эмч Г.Туяа
16:30-17:00	Сумын иргэдэд Донорын тухай сургалт зохион байгуулах	лекц	1 цаг	Цусны салбар төвийн их эмч Б.Шижирбаатар, бага эмч Г.Туяа
Сургалтын 2 дахь өдөр 2023.05.03				
09:00-10:00	Цусны бүлэг тодорхойлох шууд ба шууд бус аргууд хувийн тохироонд сорьц илгээх, хувийн тохироо тодорхойлох	Лекц	1 цаг	Цусны салбар төвийн бага эмч Г.Туяа
10:00-10:30	Цусны хувийн тохироо тодорхойлох шинжилгээ түүнд тавих шаардлага	лекц	30 минут	Цусны салбар төвийн их эмч Б.Шижирбаатар
10:30-11:30	Цусны бүлэг тодорхойлох шууд ба шууд бус аргууд	Дадлага 4 өртөөгөөр	1 цаг	Рашаант ЭМТ их эмч Жавзандаваг Бүрэгхангай их эмч Нандин-эрдэнэ Дашинчилэн лаборант Тулгажаргал Гурванбулаг лаборант Соёл-эрдэнэ
11:30-11:40	Цайны завсарлага			

11:40-13:00	Цусны хувийн тохироо тодорхойлох шинжилгээ түүнд тавих шаардлага	Дадлага 4 өртөөгөөр	1 цаг 20 минут	Дашинчилэн ЭМТ их эмч Энхжаргал Могод их эмч Булган лаборант Тулгажаргал Гурванбулаг лаборант Соёл-эрдэнэ
13:00-14:00	Цайны завсарлага			
14:00-16:00	Биологийн тохироо үзэх, орны дэргэдэх хяналт	Онол-дадлага	2 цаг	ЦСТ бага эмч Г.Туяа
16:00-17:00	Цус цусан бүтээгдэхүүний үлдэгдэл сорьцын халдваргүйжүүлэлт, устгал	Онол-дадлага	1цаг	ЦСТ бага эмч Г.Туяа

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 27-ны өдрийн А/312 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ДАДЛАГА СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1.	Өдрийн хоол	Ширхэг	80	16000	1,280,000
	Дүн				1,280,000